

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	2
1.1 Товч танилцуулга	2
1.2 Төслийн талбайн байгаль орчны төлөв байдал	2
1.3.1 Төслийн байршил	2
БҮЛЭГ 2. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	4
2.1 Байгаль орчны менежментийн 2024 оны төсөв (БОННУ-ний 5 жилийн тайлангийн БОМТ-д төсөвлөсөн зардалтай 2024 оны зардалыг уялдуулав).....	4
2.2 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2024 оны гол зорилт	4
2.3 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	5
2.4 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....	7
2.5 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	8
2.6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	9
2.7 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	10
2.8 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	11
2.8 БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	12

ХҮСНЭГТ

Хүснэгт 1 Төслөөс агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	6
Хүснэгт 2. Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	7
Хүснэгт 3. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	8
Хүснэгт 4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	9
Хүснэгт 5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	10
Хүснэгт 6. БОМТ -г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	11
Хүснэгт 7. Оролцогч талуудад тайлагнах хуваарь	12

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 Товч танилцуулга

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 18-р хороонд байрлах “Тэсо” ХХК-ийн дэргэдэх лаборатори нь 2009 онд уг байгууллагын салбар үйлдвэрийн бүтээгдэхүүн, түүхий эдэд чанарын сорилт шинжилгээ хийхээр байгуулагдсан бөгөөд зөвхөн хүнсний үйлдвэрүүдийн түүхий эд, дамжлага дундын дээж, бэлэн бүтээгдэхүүний дээжинд хими, микробиологийн шинжилгээ хийн ажиллаж байна.

Бид тогтвортой хөгжлийг эрхэмлэн хамтын үнэ цэнээр дэлхийд түүчээлэх үндэсний баялаг бүтээгч байхыг эрхэм зорилгоо болгон хэрэглэгчдийн гарт чанар, стандартын шаардлага хангасан эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнийг хүргэхээр ажиллаж байна

“Тэсо” ХХК-ийн Итгэмжлэгдсэн Лабораторид 71 төрлийн химийн бодис, микробиологийн лабораторийн 35 төрлийн тэжээлт орчныг ашигладаг.

Лабораторийн тоног төхөөрөмж, боловсон хүчний чадавхийг улам бүр сайжруулан “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага” MNS ISO/IEC 17025:2018 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж 2013 оны 1 сард Стандарт Хэмжилзүйн Газраас анх итгэмжлэгдсэн бол 2024 оны 01 сарын 09-нд 4 жилийн хугацаатайгаар давтан итгэмжлэгдэн үйл ажиллагаа явуулж байна.

Тус лаборатори нь сүү, сүүн бүтээгдэхүүн, мах махан бүтээгдэхүүн, ургамлын гаралтай хатаамал сүү, цардуул түүгээр хийсэн бүтээгдэхүүн, зайрмаг зэрэгт сард дунджаар 1500-1800 дээжинд хими микробиологийн шинжилгээ хийдэг. Лаборатори нь химич-4, микробиологич-4 лаборант-1 лабораторийн эрхлэгч-1, лаборатори эрхэлсэн захирал-1 гэсэн бүрэлдэхүүнтэй ажилладаг.

Химийн бодис, тэжээлт орчинг тусгай худалдах зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдээс худалдан авч ханган нийлүүлдэг.

1.2 Төслийн талбайн байгаль орчны төлөв байдал

1.3.1 Төслийн байршил

Лаборатори нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 18-р хорооны нутаг дэвсгэрт “Милко” ХХК-ийн үйлдвэрлэл, агуулахын зориулалттай газар дээр баригдсан 4 давхар ажлын байрны нэг давхарт түрээсийн нөхцөлтэйгээр ажлын байрыг эзэмшиж байна. Уг талбайгаас чанх урд зүгт 0.5 км-ийн зайд Таван шарын автобусны буудал, зүүн хойд зүгт 0.62 км-ийн зайд Содон хороолол, зүүн талд 0.25 км-ийн зайд 21-р хорооллоос Драгон чиглэлийн авто зам байрладаг.

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 18-р хорооны нутагт байрлах “Тэсо” ХХК-ийн Лабораторийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Зураг 1 Төслийн талбайн байршлын агаар, сансрын зураг



Газрын гадаргуу: Улаанбаатар хот нь газарзүйн байршлын хувьд ойт хээрийн бүсэд багтдаг төслийн талбай нь далайн түвшнээс дээш 1292.4-1412.8 метрийн үнэмлэхүй өндөрт байрласан байна. Харин газрын гадаргын хэвгий буюу налуу 0-4.70 (градус)-т байна.

Усан сүлжээ: Төслийн талбай байрлах бүс нутаг нь Монгол орны гадаргын усны ангиллаар Хойд мөсөн далайн ай сав, Туул голын сав газарт тус тус багтана. Сонгинохайрхан дүүрэг нь Туул голын дунд хэсгийн дунд талын хэсэгт оршдог. Энэ хэсэгт чанх хойноос Толгойтын салааны гол болон Толгойтын зүүн салааны гол нийлэн урсаж судалгааны талбайн араар тойрон далангаар урсаж Сэлбэ голд цугааж цаашлаад Туул гол цутгах ба хот дотор далангаар тусгаарлагдсан байдаг.

Цаг агаар, уур амьсгал: Сонгинохайрхан дүүрэг буюу Уулархаг хэсгийн уур амьсгал нь уур амьсгалын мужлалтаар чийглэг, хүйтэн зунтай, хахир өвөлтэй мужид багтдаг бол Туул голын хөндийн уур амьсгал нь хуурай сэрүүн зунтай, хахир өвөлтэй мужид багтана. Үнэмлэхүй их температур нь -49°C бол үнэмлэхүй халуун температур нь $+39^{\circ}\text{C}$ байна.

Хөрсөн бүрхэвч: Төслийн талбайн район нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Хангайн их мужийн Хэнтийн муж, Хэнтийн төвийн тойрогт хамаарагдана (ШУА, Газарзүйн хүрээлэн, 2009). Хээрийн судалгаа болон лабораторийн шинжилгээний үр дүнг үндэслэн төслийн талбайд бүхэлдээ уулын хар хүрэн хөрс тархсан. Судалгааны талбай бүхэлдээ хүний нөлөөлөлд өртсөн суурин газар болсон.

Ургамлан нөмрөг: Монгол орны ургамал-газар зүйн мужлалаар Сонгинохайрхан дүүрэг орчмын нутгийг Монгол-Дагуурын уулын ойт хээрийн тойрогт хамааруулдаг (Өлзийхутаг, 1989) боловч энэ нутаг Монгол-Дагуурын уулын ойт хээрийн тойрог ба Дундад Халхын хуурай хээрийн тойргийн зааг дээр оршдог учраас уулын хээр ба жинхэнэ хээрийн хэвшлийн ургамалжилтыг хосолсон шинж чанартай байна. Төслийн талбайд хялгана хиаг алаг өвт бүлгэмдэл тархах унаган хэвшинжтэй боловч судалгааны хашаалсан талбай 100 хувь хатуу хучилтай байна.

Амьтны аймаг: Сонгино хайрхан дүүрэг орчмын нутаг бол манай орны ойт хээрийн бүсэд хотжилтын бүсэд хамаарна. Хотжилтын нөлөөгөөр хүнд ойромсог амьтад амьдарна.

Хүн ам, эдийн засаг, зам харилцаа: Сонгинохайрхан дүүрэг нь хотын баруун хэсэгт, Сонгинохайрхан уулын бэлд оршдог бөгөөд 1200.6 км² газар нутагтай ба нийслэлийн Баянгол, Хануул дүүргүүд, Төв аймгийн Алтанбулаг, Баянчандмань, Батсүмбэр, Борнуур, Баянцогт сумдуудтай хиллэн оршдог.

БҮЛЭГ 2. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2.1 Байгаль орчны менежментийн 2024 оны төсөв (БОННУ-ний 5 жилийн тайлангийн БОМТ-д төсөвлөсөн зардалтай 2024 оны зардалыг уялдуулав)

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зардал /мян.төг/	Тухайн жил БОМТ зардал	2024 оны төсөв
		2020-2025 он	2020-2025 он	2024 он
1	Сөрөг нөлөөллийг бууруулах	Агаарын чанар 500 мян.төг	2106 мян.төг	100 мян.төг
		Хөрс 6810 төг		2 400.0 мян.төг
		Ус 3220.0 мян.төг		
2	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны төлөвлөгөө	8850.0 мян.төг	768 мян.төг	2500.0 мян.төг
3	Нөхөн сэргээлт, ногоон байгууламж	3840.0 мян.төг	1428.0 мян.төг	160 мян.төг
4	Осол эрсдэлийн төлөвлөгөө	974.0 мян.төг	194.8 мян.төг	500.0 мян.төг
5	Хог хаягдлын менежмент	3020.0 мян.төг	600.0 мян.төг	2 160.0 мян.төг
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	4640.0 мян.төг	928.0 мян.төг	334.0 мян.төг
7	Байгаль орчны аудит удирдлага	3000.0 мян.төг	600.0 мян.төг	-
8	БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын менежмент	4000.0 мян.төг	800.0 мян.төг	100.0 мян.төг
9	БОМТ-ний 5 жилийн зардал	38 854.0 мян.төг	7428.8 мян.төг	8 254.0 мян.төг

2.2 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2024 оны гол зорилт

Хуулиар хүлээсэн үүрэг Байгаль орчны ерөнхий үнэлгээ, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд тусгагдсан шаардлага үйлдвэрлэл, үйлчилгээгээ олон улсын стандартын шаардлагад нийцүүлэхээр компанийн байгаль орчны гүйцэтгэлийг сайжруулахаар ажиллаж байна. Үүний нэг хэсэг болсон байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2024 онд хамаарах ажлыг түүвэрлэн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын дагуу боловсрууллаа.

- БОМТ-нд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ажиллагсдын үүрэг хариуцлагыг тогтоож, хэрэгжүүлэх;
- Ажилтан ажиллагсад нэг бүр байгаль орчны хамгаалах асуудалтай холбоотой үүрэг хариуцлагаа бүрэн ойлгосон байхын зэрэгцээ тэдэнд үүргээ биелүүлэхэд нь туслах бэлтгэл сургалтанд хамрагдсан ур чадвартай мэргэжилтэн болгох;
- Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдлийг урьдчилсан тооцсноор байгальд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг бууруулах, байгаль орчны төлөв байдлыг сайжруулах, хэвийн хадгалж, хамгаалах;
- Химийн лаборатори төслийн үйл ажиллагааны шат дамжлага бүрт технологийн журам, зааврыг байгаль орчны хууль тогтоомжийн холбогдох зүйл заалт, стандартын шаардлагад нийцүүлж, сайжруулах;

**Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 18-р хорооны нутагт байрлах “Тэсо” ХХК-ийн
Лабораторийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

- e) Дүүргийн удирдлага, хяналтын байгууллага, ард иргэдтэй байгаль хамгаалах асуудлаар зөвлөлдөж тэдний саналыг авч хамтран ажиллах;
- f) Байгаль орчин хамгаалах сөрөг нөлөөллийг багасгах талаар ажиллагсад зааварчилгаа өгч гарын авалга материалаар хангах;
- g) Байгаль орчны менежментийн асуудлаар БОННУ-ний тайланд тусгагдсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх.

2.3 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутагт орших “Тэсо” ХХК-ийн “Химийн лаборатори” төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл бага хэдий ч химийн бодистой харьцаж ажиллах, урвалж уусмал бэлдэх явцад лабораторийн дотоод агаарт хортой бодис тархаж түүгээр амьсгалах, ажиллагсад бодис урвалжид түлэгдэх, хордох зэрэг нөлөөллүүд гарч болзошгүй.

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 18-р хорооны нутагт байрлах “Тэсо” ХХК-ийн Лабораторийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 1Төслөөс агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Агаар	Хүнсний хими, микробиологийн лабораторид дотоод агаарын бохирдол үүсэх, дээж бэлтгэх өрөөний агаараас тогтмол дээж авч ажиллах, хяналтын тогтолцоог бий болгох	Химийн лаборатори	удаа	50.0 мян.төг	2	100.0 мян.төг	2024 онд, Жилд 2 удаа	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 5885:2008
		Лабораторийн агааржуулалтыг хянах төхөөрөмжтэй болох, гарах агаарыг шүүлтүүрээр дамжуулах, тогтмол ажиллуулах	Химийн лаборатори				-	-	Төсөл хэрэгжүүлэгч
2	Хөрс, Ус-химийн бодис урвалж, нянгийн хаягдлаар хөрс, ус бохирдох	Химийн бодис урвалжыгн хаягдлыг тусгай саванд хадгалах	Үйл ажиллагааны туршид	Улирал д 1 удаа	600.0 мян.төг	4	2 400.0 мян.төг	2024 онд, Жилд 4 удаа	Хог хаягдлын тухай хууль MNS 0900:2018 Усны чанар эрүүл ахуйн стандарт
Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал						2 500.0 мян.төг			

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 18-р хорооны нутагт байрлах “Тэсо” ХХК-ийн Лабораторийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2.4 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Хүснэгт 2. Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Цэцэрлэгжүүлэлт, Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Нийслэлийн Байгаль Орчны Газраас зааж өгсөн талбайд лабораторийн ажилтны тоогоор мод тарина	Нийслэлийн Байгаль Орчны Газраас зааж өгсөн талбайд лабораторийн ажилтны тоогоор мод тарина	ш	13	20,000	160,000	2024 он, жилд 1 удаа	
	Нийт						160 мян.төг		

Мод тарих байршил



Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 18-р хорооны нутагт байрлах “Тэсо” ХХК-ийн Лабораторийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2.5 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 3. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Ангилал	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
		1	2	3	4	5	6	7	8
1	Үерийн аюул, хур тунадас	Зун, намрын улиралд үргэлжилсэн буюу их устай бороо орох, үйл ажиллагаа саатах	Үерийн далан хаалтын бүрэн бүтэн байдлыг хангах, засварлах, хог хаягдлыг цэвэрлэх	Төслийн талбайн хэмжээнд	1	-	-	2024 он	MNS 6010:2016 Гамшгийн холбогдолтой нэр томъёо, тодорхойлолт, ерөнхий анги
2	Галын аюулгүй ажиллагаа	Талбайн тоног төхөөрөмжийн гэмтэл, шалбарсан утас, цахилгааны хэлбэлзэл, цахилгааны эх үүсвэрийн хүчдэл хэлбэлзэх	Тоног төхөөрөмжийн гэмтлийг тухай бүр нь засах, цахилгааны утсыг шалгах	Химийн лаборатори	-	-	Дотоод зардал	2024 он	MNS 4244:1994 “Хөдөлмөр хамгааллын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага” 5390:2004 Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага
			Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Химийн бодисын агуулах болон бусад газруудад	3	150,000	500,000	2024 он Улиралд 1 удаа	
3	Хөдөлмөр хамгаалал	Ажлын байрны хөдөлмөр, эрүүл ахуйн нөхцөлийг хангаагүйгээс ажиллагсадын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх	Химийн бодистой харьцаажжиллах ажилчдын хувцас сайжруулах	Химийн лабораторийн ажилтнууд	6		Хөдөлмөр хамгааллын зардалд	2024 он	MNS 4968: 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага
			Химийн бодистой харьцаажжиллах ажилчдад химийн бодистой ажиллах, аюул ослын үед авах	Лабораторийн нийт ажилтнууд	12		Сургалтын зардалд	2024 он	

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 18-р хорооны нутагт байрлах “Тэсо” ХХК-ийн Лабораторийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

			арга хэмжээний сургалт зохион байгуулах						
	Нийт						500,000		

2.6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1	Ахуйн	Ажилчдын байранд хогийн сав байрлуулж, хогийг ангиалан ялгуулж байх	Талбайн хэмжээнд	тогтмол	-	-	-	2024 он	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
		Ил задгай хог хаяхгүй байх талаар анхааруулга санамж бүхий самбар, тэмдэгжүүлэлттэй болгох	Талбайн хэмжээнд	тогтмол	-	-	-	2024 он	
2	Орчны гадна талбай	Орчны бохирдлоос урьдчилан сэргийлэхийн тулд бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах	Талбайн хэмжээнд	тухай бүр	-	-	-	2024 он	
3	Аюултай	Нян судлалын лабораториос гарах хаягдал		удаа	180,000	12	2,160,000	2024 он	“Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах” журам компаний дотоод журам
	Нийт						2,160,000		

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 18-р хорооны нутагт байрлах “Тэсо” ХХК-ийн Лабораторийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2.7 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№		Хяналт шинжилгээний үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
		1	2	3	4	5	6	7
1	Агаар орчин	PM10, PM2.5 тоос	1.Төслийн гаднах талбайд -1 цэг 2.Химийн лаборатори доторх агаар 3.Нян судлалын лаборатори	Жилд 2 удаа	32,000	64,000	БОХТЛ	MNS 5885:2008 MNS 4585:2016 MNS 6063:2010
		NO ₂ , SO ₂ CO, Нийт тоос тодорхойлох, Дуу чимээ, шуугиан, доргио						
		Агаар дахь хүнд элементүүд /14 элемент/						
2	Хөрс бохирдол	Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд	1.Төслийн талбайд хог хаягдлын цэг	Жилд 2 удаа	25,000	50,000	ГЗГЭХ-ийн Хөрс судлалын лаборатори	
		Хүнд элементин шинжилгээ /8 элемент/						
3	Усан орчин бохирдох	Ерөнхий хими	- Төвлөрсөн эх үүсвэрийн оролт дээр-1 -Бохир усны гаралт дээр -1 /Бохирдуулагч бодис тус бүрээр/	Жилд нэг удаа	50,000	50,000	Монгол ус Төрийн өмчит үйлдвэрийн газар	1.Усны чанар эрүүл ахуйн стандарт MNS 0900:2018 2. Байгаль орчин, аялалжуулчлалын сайдын 2019.09.27-ны өдрийн А/543 дугаар тушаал . “Ус бохирдуулах аюултай бодисын жагаалт”
		Хүнд элементийн шинжилгээ						
		Нийт				334,000		

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 18-р хорооны нутагт байрлах “Тэсо” ХХК-ийн Лабораторийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2.8 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 6. БОМТ -г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь				Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2024 он					
			1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал		
1	Тухайн жилийн БОМТ-г боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг тайлагнах	-	+			+	Лабораторийн эрхлэгч	Гамшгаас хамгаалах тухайхууль 27.1
2	- Байгаль орчин хамгаалах - Хөдөлмөр хамгаалал зэрэг сэдвээр сургалт, сурталчилгаа зохион байгуулах	Сургалтын зардалд			+		Лабораторийн эрхлэгч	
3	Үйл ажиллагааны зардлаар Хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлын тухай хууль, журам, стандартын биелэлтийг хангах зорилгоор дотоод хяналтыг зохион байгуулах	-		+			Лабораторийн эрхлэгч	
4	Гал түймрээс урьдчилан сэргийлэх Хөдөлмөр хамгаалах, аюулгүй ажиллагааны талаар мэдээллийн самбар гаргаж байрлуулах	100,000			+		Лабораторийн эрхлэгч	
5	Тухайн жилийн БОМТ-ий хэрэгжилтэнд байнга хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллах					+	Лабораторийн эрхлэгч	
	Нийт	100,000						

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 18-р хорооны нутагт байрлах “Тэсо” ХХК-ийн Лабораторийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2.8 БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Хүснэгт 7. Оролцогч талуудад тайлагнах хуваарь

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	СХД-н 18-р хорооны иргэд	Уулзалт	Жил бүрийн БОМТ-ний хэрэгжилт үр дүнгийн тайлан	Жил бүр	-	Лабораторийн эрхлэгч	Хорооны иргэдийн уулзалтын байранд эсвэл компанийн хурлын өрөө
2	БОАЖЯ-ны ХБОБНУ-ын газарт	Хэвлэмэл тайлан	БОМТ хэрэгжилт	Жил бүрийн 12 сард	-	Лабораторийн эрхлэгч	-
3	БОАЖЯ	www.eic.mn	БОМТөлөвлөгөө	Тухай оны 01 сар	-	Лабораторийн эрхлэгч	цахимаар
	Нийт				-		